
АНТРАКТИД СУДЛАЛЫН ТӨВ

Хариуцагч - Доктор, профессор Л.Дүгэржав

ШУТИС-ийн “Антарктид судлал”-ын төв нь 2013 онд байгуулагдсан бөгөөд “Монгол орны цэвдгийн хилийн ба глобал цаг уурын өөрчлөлттэй холбоотой эрдэм шинжилгээ, суурь судалгааны ажлуудыг хийж ирсэн.



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 10 өдөр Дугаар А-108 Улаанбаатар хот

Төв байгуулах тухай

ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны төвийн нийтлэг журам, Ректорын эрхлэлийн 5 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийн үндэслэн ТУШААХ нь:

1. “Антрактид судлалын төв”-ийг 2013 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс ГГТС-ийг түшиглүүлэн байгуулж, төвийн дүрмийг хавсралтаар батлуулсугай.

2. “Антрактид судлалын төв”-ийн захирлаар ГГТС-ийн Газрын тосны профессорын багийн ахлах багш А.Баасанжаргалыг ажиллуулж, үйл ажиллагааны орлогоос цалинжуулахыг ГГТС-ийн захирал /Д.Оюун/-д зөвшөөрсүгэй.

3. Шинжлэх ухаан технологийн судалгаа, туршилт үйлдвэрлэлийн бүртгэлийн гэрчилгээ олгохыг Эрдэм шинжилгээ технологийн проректор /Б.Очирбат/-д даалгасугай.

РЕКТОР БАТБАЯР



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТӨВИЙН БҮРТГЭЛИЙН

ГЭРЧИЛГЭЭ

БҮРТГЭЛИЙН ДУГААР: 44

АНТАРКТИД СУДЛАЛЫН ТӨВ

Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль

2013 оны 6 дугаар сарын 3-ны өдөр

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ /Б.ОЧИРБАТ/

2018.10.01 2 жил

Сүүлийн жилүүдэд Антарктид тивийн Ливингстоны арал дээр “Монгол Улсын Антарктид судлал” Чингис хааны нэрэмжит баазыг байгуулах ажлыг удирдан, зохион байгуулж байна.



Өмнө зүгт, алсын алсад, луужингийн зүү зөвхөн хойд зүгийг заадаг ер бусын гайхамшигт газар бий. Тэнд хязгааргүй хүйтэн, салхи, цас, мөс өндөр уулс ноёлдог бөгөөд түүнийг АНТАРКТИД тив хэмээн нэрлэнэ.

Өнгөрсөн зуунд, ялангуяа сүүлийн 50 жилд Антарктидын бүс нь дэлхий дахины шинжлэх ухааны судалгааны чухал талбар

болсон юм.

Өнөөдөр Антарктидын энх тайван, шинжлэх ухааны тив болгоход Антарктидын Олон Улсын хэлэлцээр (Antarctic treaty-AT), Антарктидын судалгааны зөвлөл (The Scientific Committee on Antarctic Research –SCAR), мөн Үндэсний Антарктидын Хөтөлбөрүүдийн Менежерүүдийн Зөвлөл (Council of Managers of National Antarctic Programs-COMNAP) гэсэн гурван гол хүчин нөлөөлж байна. Дээрх байгууллагууд нь тус тивийн талаарх олон улсын судалгаа шинжилгээ хийх, судалгааны удирдлагын зохион байгуулалтыг зөвлөл мэдээлэлээр хангах мөн хүнд нөхцөлд аль болох үр дүнтэй судалгааны ажил хийхэд чухал хувь нэмэр оруулж байна.

COMNAP-ийг анх 1988 онд Антарктидын Олон улсын Хэлэлцээрийн зөвлөлийн 22 орны Антарктидын хөтөлбөрийн менежерүүд үүсгэн байгуулсан. Антарктидын ОУ-ын хэлэлцээр болон түүний Байгаль Орчныг Хамгаалах Протокол (”Байгаль Орчны Протокол” буюу “Мадридын Протокол”)-оор Антарктид тив бол энх тайван, шинжлэх ухаанд зориулагдсан байгалийн баялаг - гэсэн ойлголтын хүрээнд улс орнууд мэдлэг, чадвараа хуваалцаж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд гол суурь болдог байна.

Шинжлэх ухаан бол Антарктидын ОУ-ын Хэлэлцээрийн мөнгөн тэмдэгт юм. SCAR нь Антарктид судлалын эрдэмтдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангадаг бөгөөд тэднийг шууд төлөөлдөг. COMNAP нь Антарктидад судалгааны үйл ажиллагаагаа явуулдаг эрдэмтдээр дамжуулан шинжлэх ухааны хамтарсан судалгаа хийдэг бөгөөд мөн шаардлагатай үед тусламж дэмжлэгийг үзүүлдэг байна.



Доктор, профессор Л.Дүгэржав бол анх удаа өмнөд туйлын “00” цэг буюу S900–т хүрч Улсынхаа далбааг мандуулсан анхны монгол хүн юм.

Баруун Антарктидын нэгэн нэргүй оргилыг “Дүгэржавын оргил” “Dugerjav peak” хэмээн олон улсын гэрээний орнуудын удирдах байгууллага (CONNAP)-ын шийдвэрээр нэрлэсэн.



2015 онд Монгол Улсыг олон улсын Антарктидын гэрээнд нэгдэн орох асуудлыг Засгийн газраар санаачлуулж, УИХ-р соёрхон батлуулснаар элсүүлэх ажлыг зохион байгуулсан. Монгол Улс Олон улсын Антарктидын гэрээний 53 дахь гишүүн орон болсон.



